

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ширчингийн Сономцэрэн	Дугаар	L037
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянзүрх дүүрэг
Төрсөн газар	Ховд аймгийн Дарви сум	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сутай уулын хошууны Дэлгэрийн хийд	Сүм хийдийн дугаар	ХОДР 105
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Ховд аймгийн Дарви сумын Дэлгэрийн хүрээ буюу Ригэмбэл хийд

Манай хошуу Сутай уулын хошуу. Засагт хан Завханд төвлөрч байхад орлодог ноён нь манай ноён байсан гэж байгаа. Аюур да гэдэг ноён байсан. Одоогийн Ховд аймгийн Дарви сум. Тэнд Дэлгэрийн хийд буюу Эрээгэмпил хийдэд би 9 арай хүрээгүй байхдаа 1 өвгөн ламын тогоо бариад шавилаад 18, 19 хүртлээ сууж байсан.

Манай хийд 600-д ламтай байсан. Манай хошууны хувилгаан нь Хар-лам гэдэг миний багш. Би хийддээ байхдаа энэ хувилгаан ламын гудамжинд байсан. Намайг 18 настай байхад хүрээ хаагдсан. 19 настай цэрэгт татагдаад буцаад 20-той татагдаж буцаад, 21-тэй татагдаад буцаад 22 настай цэрэгт явсан. Дөрвөн хүүхэд л буцаагаад байсан. Эрүүл байдаг, яагаад ингэж буцаагаад байна гэсэн. Тэгсэн манай хүргэн ах сумд нэг ажилд орсон. Тэр хүн ээжид ярьсан байгаа юм. Энэ дөрөв чинь их

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нөлөөтэй том лам нарын дэргэд байсан гээд буцаад байсан юм гэнэ гэж. 1938 онд 22 настай хотод цэрэгт ирээд улс төрийн туслах болсон. Цэрэгт 15 жил болсон. Цэргээс халагдаад Сайд нарын зөвлөлийн харьяа Нүхтийн амралтын орлогч даргаар очсон. Нэг жил орлогчоор ажиллаад дарга болж 17 жил болсон.

Манайх Цогчэн, Дүйнхор, Манба, Жүд, Чойр гэсэн 5 дацантай хамгийн доривтой нь Цогчэн, Дүйнхор хоёр юм. Цогчэн гэдэг нь бүх юмны суурь, Манба гэдэг нь эмнэлгийн талын, Чойр гэдэг нь одоогоор улс төр, Жүд гэдэг нь гүүшийн талын дуган юм. Манба, Жүд хоёр нэг дугантай. Чойр, Дүйнхэр 2 нэг дугантай, Цогчэн, тусдаа дугантай байсан.

Би Цогчэн уншлагаа дуусгаад Чойрт орсон. Шидэвийн зиндаа буюу доороосоо 2 дахь зиндаа хүртэл явсан. Чойрын нийт есөн зиндаатай байсан. Зиндаа тус бүрт суралцах хугацаа харилцан адилгүй байсан. Манай зиндаа 50 гаран хүнтэй байсан.

Цогчэнд олон магтаал байдаг. Хангалууд хурна. Гомбо, Намсрай, Жамсран, Очирваань гээд. Мөн бүтээлүүд хурна. Тэр дотор их олон чогууд явдаг. Өвөл болохоор 7 хоногийн ерөөл өдөр, шөнөгүй хурна. Зун мэгзэм хурна. Мэгзэмийн бүтээлийг мах идэхгүй цагаан цаваар хурдаг байсан. Цагаан сараар Цэдор Гүдэр гэж хурна. 29-нд сор зална. Чахарын лам гэж байсан. Тэр лам ганцаараа сор зална. Сар нямба хийж хүнтэй уулзахгүй, гадуур явахгүй гэртээ сууж байж 29-нд сороо залдаг байсан. Гэрийнхээ үүдэн дээр тэмдэг босгочихно. Тэрийг нь хараад хүн орохгүй. Сор гэдэг чинь босоо хүн шиг юм байдаг байсан. Манай хийдэд цам гарна. 32 дүр гарна. Би цамд хоёр жил харайсан. Тэр дотроос Чогдзамандий, Чойжоо гэсэн хоёр дүрд хэр баргийн хүн гарахгүй. их сайн лам гарах ёстой. Нэлээн нямба хийсэн хүн гарна. Цам намар гарна. Одоогоор 9,10 дугаар сард гардаг байсан. Дүйнхор сүмийн үүдэн дээр хоёр өдөр үргэлжилнэ. Майдар тусдаа эргэнэ. Ганцхан өдөр эргэнэ. Нэг ногоон морин толгойтой нь Янсан ядам, гурван ногоон морин толгойтой нь Дамдин ядам. Янсан ядамаар нь эргэнэ. Ганжуур хурна. Манайд Ганжуур эргэнэ гэдэггүй байсан. Зүгээр л хурал номдоо хурна.

Чойрын сургалтын игчаа нь Сэра игчаатай. Манай хийд дээр гавжийн дамжаа, аграмбын дамжаа барина. Жилд нэг удаа гавжийн дамжаа барина. Яг тогтоосон тоо байхгүй. Жилд сайн бол 3, 4 хүн л байна. Дамжаагаа олон хоног барина.

Манай хийдийн ойролцоо өөр хийд гэх юм байгаагүй. Манайхан одоогийн Говь-Алтайн Тонхилын хийдэд очиж Чойрын ном үздэг байсан. Тонхилын хийдтэй харилцаа холбоотой байсан гэж үзэж болох байх. Манай хүрээнд том төвд лам байгаагүй. Доогуур ганц нэг хүн байсан байж магадгүй юм.

Өмнө Чойр гэж сайн лам байсан. Гурван жил болоод л Чойр лам солигддог байсан. Аль л номтой сайн хүнээ Чойр ламд тавьдаг байсан. Түвдэн амбажий гэж байсан. Пилдэн аграмба гуай гэж байсан. Анчгийн дооромбо лам гуай гэж байсан. Хутагт хувилгаад гэдэг чинь яах аргагүй давхар хүн. Манай багшийг Архангай, Булганыхан тэр чигээрээ шүтнэ. Энд хүрээнд гавж болоход Сонгины өвөр энэ тэр чинь Архангай, Булганы суурь хонь, суурь адуу, суурь үхрээр дүүрчихсэн юм гэнэ лээ. Тэгээд л морь тэргээр айраг цагаа, цагаан идээ зөөгөөд байдаг байсан гэж манайхны лам нар ярьдаг байсан юм. Энэний түрүүчийн лам нь Торгон Дамба гэж байсан. Сахал ихт Гунаажав гэдэг айлаас төрсөн юм. Манай хийд дээр 78 хүрээд таалал болсон юм уу даа. Тэрний дараа Чойрдайчимба гуай гэдэг хүнээс энэ лам гарсан. Тэгээд энэ лам чинь 1939 оны бариа тавиагаар хаачсан нь ч мэдэгдэхгүй алга болчихсон. Яасан нь мэдэгдээгүй. Анх таван настайд нь залж байсан.

Манай хийд гурван жастай байсан. Цогчэн жас, Чойр жас, Жүд жас гэж байсан. Цогчэн жас, Чойр жас хоёр нь их том, баян мал ихтэй. Манай энд лам хувраг нь аймаглаж суудаггүй, зиндаалаад явчихдаг байсан. Лам нарын хашаа нь хийдийнхээ араар голдуу байдаг байсан. Манай

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хийдэд лүйжинч хар байсан. Тэд жүдэд л хурна. Ер нь зодоч нар цөөхөн байсан юм шүү. Хийдийн ойролцоо Шинэ худалдаа гэсэн наймааны газар байсан. Хятадын худалдааны газар юм. Тэр үеийн лам нарт цалин гэж байгаагүй. Ердөө жандагийн юмаар л амьдардаг байсан.

Хийд 1937 оны намар бүр хаасан. Эзгүй хашаа, эзгүй гэр, эзгүй юм их үлдсэн. Хийдийг яг 1937 оноосоо эхэлж зөөгөөгүй. 1938, 39 оноос эхэлж буулгасан. 1938 онд би цэрэгт явсан. Баруун талдаа хамгийн түрүүнд манай хийд сэргээгдсэн. Тэр лам нарын үлдэгдэл хэдэн өвгөчүүл байсан юм. Тэднүүс чинь дор нь гаргаад ирсэн. Тэгээд хөгшчүүл нь үхэж үрэгдээд, залуучууд нь жаахан сулхан л болчихоод байгаа юм. Сэргэсэн тэр хийд уг нь байх нь байж л байгаа. Одоо энэ Монгол улсад ядуурал их байна, энэ л байхгүй болоосой, арилаасай гэж бодож сууна.